



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 7 сарын 17 өдөр

Дугаар A/40

Хэрлэн сум

**Байгууллагын тамга, тэмдэг түших
албан хаагч томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолын хавсрал "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" 4.1.2, 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралт "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам"-ын 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын тамга тэмдэг түших албан хаагчаар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн Ш.Эрдэнэжаргалд томилсугай

2. Холбогдох журам зааврын дагуу тамга тэмдгийг хэрэглэх, хадгалах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллахыг (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Баярцолмон)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНТУЛГА

